



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/110

Улаанбаатар хот.

Төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Татварын ерөнхий хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 27<sup>1</sup>.6.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын татварын албаны ажилтан, албан хаагчийн сургалт, хөгжлийн хөтөлбөр”-ийн хавсралт төлөвлөгөөг шинэчлэн баталсугай;

2.Төлөвлөгөөнд туссан ажлыг цаг хугацаанд нь удирдан зохион байгуулах, хамтран оролцох замаар хэрэгжүүлэхийг зохион байгуулалтын бүтцийн нэгж, татварын албадын дарга нарт үүрэг болгосугай;

3.Төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, тайлан, үр дүнг нэгтгэх, холбогдох нэгжид тайлагнах ажлыг Сургалтын төв /Б.Бадамцэцэг/-д үүрэг болгосугай;

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Л.Нэргүй/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД  
ДЭД ДАРГА



Б.ЗАЯАБАЛ

## ТАТВАРЫН АЛБАНЫ АЖИЛТАН, АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ШИНЭЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

| №                                                                                                                    | Хэрэгжүүлэх арга хэмжээ                                                                                                                  | Хийж гүйцэтгэх ажил                                                                                                                                                          | Шалгуур үзүүлэлт                                                                                                                                                                                 | Хүрэх үр дүн                                                                                                                                                                      | УХАА Удирдах, Зохион байгуулах              | Хариуцан гүйцэтгэх                                |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------|---------------------------------------------------|
| <b>1. Татварын албаны сургалтын төрөл, хэлбэрийн тогтолцоог шинэчлэн боловсруулах, бүх шатны сургалтыг хөгжүүлэх</b> |                                                                                                                                          |                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                   |                                             |                                                   |
| 1.1                                                                                                                  | Татварын албаны ажилтан, албан хаагчийн албан тушаалын тодорхойлтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн сургалт зохион байгуулах | 1. Хувь хүний хөгжлийн сургалт;<br>3. Байгууллагын болон харилцааны соёлын сургалт;                                                                                          | Тоо: Жил бүр төлөвлөгөөнд тусгаснаар<br><b>Чанар:</b> Жилийн төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрт дурдсан агуулгад нийцсэн сургалтын материал боловсруулагдсан байна.<br><b>Хугацаа:</b> 2019-2020 он | Сургалтын хөтөлбөр боловсруулж, удирдлагаар батлуулан, дурьдсан албан хаагчдыг хамруулан, санал асуулгаар үр дүн гарсан байна.                                                    | Сургалтын төвийн дарга                      | Сургалтын төвийн багш нар                         |
|                                                                                                                      |                                                                                                                                          | 1. Санхүү, татвар, нягтлан бодох бүртгэлийн англи хэлний сургалт;<br>2. Олон улсын татварын сургалт;<br>3. Олон улсын байгууллагын болон дотоодын зөвлөх багш нарын сургалт; | Тоо: Жил бүр төлөвлөгөөнд тусгаснаар<br><b>Чанар:</b> Жилийн төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрт дурдсан агуулгад нийцсэн сургалтын материал боловсруулагдсан байна.<br><b>Хугацаа:</b> 2019-2020 он | Хамтарсан болон тусгайлан явуулах сургалтын хөтөлбөр боловсруулж, удирдлагаар батлуулан, дурьдсан албан хаагчдыг хамруулан, санал асуулгаар үр дүн гарсан байна.                  | Татварын удирдлага хамтын ажиллагааны газар | Гадаад сургалт, Олон улсын татвар хариуцсан хэсэг |
|                                                                                                                      |                                                                                                                                          | 1. Авлигаас урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалт;<br>2. Төрийн албаны тухай хууль, холбогдох журам, дүрмийн сургалт                                                          | Тоо: Жил бүр төлөвлөгөөнд тусгаснаар<br><b>Чанар:</b> Жилийн төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрт дурдсан агуулгад нийцсэн сургалтын материал боловсруулагдсан байна.<br><b>Хугацаа:</b> 2019-2020 он | Мэргэжлийн байгууллагатай хамтарсан болон тусгайлан явуулах сургалтын хөтөлбөр боловсруулж, удирдлагаар батлуулан, албан хаагчдыг хамруулан, санал асуулгаар үр дүн гарсан байна. | Төрийн захиргааны удирдлагын газар          | Татварын албадын Төрийн захиргааны нэгж           |

|     |                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                      |                                              |
|-----|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------|
|     | 1. Авлигаас урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалт;<br>2. Албан тушаал сэлгэх, шилжих чиг үүргийн сургалт;<br>3. Байгууллагын болон харилцааны соёлын сургалт;                     | Тоо: Жил бүр төлөвлөгөөнд тусгаснаар<br><b>Чанар:</b> Жилийн төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрт дурдсан агуулгад нийцсэн сургалтын материал боловсруулагдсан байна.<br><b>Хугацаа:</b> 2019-2020 он | Мэргэжлийн байгууллагатай хамтарсан болон тусгайлан сургалтын хөтөлбөр боловсруулж, батлуулан, албан хаагчдыг хамруулан, холбогдох нэгжид тайлагнасан байна.                                                                         | Татварын албаны нэгжийн ТУАБ нар             |
| 1.2 | Татварын албаны ажилтан, албан хаагчид ажлын аливаа асуудлаар мэдлэг, мэдээллээ солилцох, багаар хамтран хэлэлцэх боломж нөхцөлөөр хангах, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах | Тоо: 1<br><b>Чанар:</b> Татварын улсын /ахлах/ байцаагчид хамтран мэдлэг, туршлагаа хуваалцах нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.<br><b>Хугацаа:</b> 2019 он                           | Татварын хяналт шалгалтын байцаагчид болон магадлагч нарыг хариуцсан ажлын чиглэл, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд багаар ажиллуулж хэлэлцүүлэгийг зохион байгуулснаар нэгж хоорондын ажлын уялдаа холбоо сайжирсан байна. | Сургалтын төв<br>Сургалтын төвийн ТУБ Н.Туул |
|     |                                                                                                                                                                                  | Тоо: 1<br><b>Чанар:</b> Татварын улсын /ахлах/ байцаагчид хамтран мэдлэг, туршлагаа хуваалцах нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.<br><b>Хугацаа:</b> 2020 он                           | Хариуцсан ажлын чиглэл, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд багаар ажиллуулж, дурьдсан сэдвээр хэлэлцүүлэгийг зохион байгуулснаар алба хоорондын уялдаа холбоо сайжирсан байна.                                                | Татварын албад<br>Сургалтын төв              |
| 1.3 | Татварын албаны ажилтан, албан хаагч, хамт олон, нэгжээс санаачилсан шинэ санаа, сайн туршлагыг татварын албаны хэмжээнд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах               | Тоо: Жил бүр<br><b>Чанар:</b> Туршлага солилцох сургалт, зөвлөгөөн зохион байгуулснаар албан хаагч, нэгж, албадын ажлын үр дүн дээшилнэ.<br><b>Хугацаа:</b> 2020                                 | Татварын албаны хэмжээнд туршлага солилцох, хэлэлцүүлэг зөвлөгөөнийг зохион байгуулсан байна.                                                                                                                                        | Татварын албад<br>Сургалтын төв              |

|                                                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                        |                                                                                                                                                                                      |                                           |                                                    |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------|----------------------------------------------------|
| <p>1.4</p> <p>Гадаад сургалт, туршлага судлах хөтөлбөрт хамрагдсан ажилтан, албан хаагчийн сургалтаар олж авсан мэдлэг, мэдээллийг татварын албаны хэмжээнд түгээх, тайлагнах ажлыг зохион байгуулах</p> | <p>Гадаад сургалт, туршлага судлах хөтөлбөрт хамрагдсан ажилтан, албан хаагч сургалттай холбоотой мэдээлэл, материал, сургалтад хамрагдсан талаар холбогдох нэгжид тайлагнах</p> | <p><b>Тоо:</b>Тухай бүр<br/><b>Чанар:</b> Татварын албаны ажилтан албан хаагчид гадаад сургалт болон туршлага судлах хөтөлбөрт хамрагдсан тухай тайланг журамд заасан хугацаанд тайлагнасан байна.<br/><b>Хугацаа:</b>2019-2020 он</p> | <p>Татварын албаны ажилтан албан хаагчид гадаад сургалт болон туршлага судлах хөтөлбөрт хамрагдсан мэдээлэл, тайланг холбогдох нэгжид журамд заасан хугацаанд тайлагнасан байна.</p> | <p>Төрийн захиргааны удирдлагын газар</p> | <p>Татварын удирдлага хамтын ажиллагааны газар</p> |
| <p>1.5</p> <p>Татварын албаны ажилтан, албан хаагчийн ажлын чиг үүрэг, хувь хүний хөгжлийн талаар зөвлөх багш урьж зорилтот сургалт, семинар зохион байгуулах</p>                                        | <p>Татварын албаны ажилтан, албан хаагчийн ажлын чиг үүрэг, хариуцсан ажлын хүрээнд зөвлөх, арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулах</p>                                    | <p><b>Тоо:</b>Жилийн төлөвлөгөөнд тусгагдснаар<br/><b>Чанар:</b> Татварын албаны ажилтан, албан хаагчдын хэрэгцээ,цаг үеийн шаардлагад нийцсэн сургалт, төрөлжүүлсэн семинар зохион байгуулна.<br/><b>Хугацаа:</b>2019-2020 он</p>     | <p>Тусгай хөтөлбөрөөр зохион байгуулсан сургалтад холбогдох ажилтан албан хаагчид бүрэн хамрагдсан байна.</p>                                                                        | <p>ЗББН-үүд</p>                           | <p>Татварын албад</p>                              |
|                                                                                                                                                                                                          | <p>Татварын албаны ажилтан, албан хаагчдад хувь хүний хөгжлийн талаар зөвлөх багш урьж зорилтот сургалт, семинар зохион байгуулах</p>                                            | <p><b>Тоо:</b>Жилийн төлөвлөгөөнд тусгагдснаар<br/><b>Чанар:</b> Татварын албаны ажилтан, албан хаагчдын цаг үеийн шаардлагад нийцсэн зорилтот сургалт, төрөлжүүлсэн семинар зохион байгуулна.<br/><b>Хугацаа:</b>2019-2020 он</p>     | <p>Тусгай хөтөлбөрөөр зохион байгуулсан зорилтот сургалтад холбогдох ажилтан албан хаагчид бүрэн хамрагдаж семинар зохион байгуулсан байна.</p>                                      | <p>Төрийн захиргааны удирдлагын газар</p> | <p>Сургалтын төв</p>                               |



## 2. Татварын албаны хэмжээнд манлайлал, заах арга зүйг хөгжүүлэх

|     |                                                                                                                                                             |                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                     |                                    |                                                                              |
|-----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------|------------------------------------------------------------------------------|
| 2.1 | Туршлага судлах, багшлах ур чадвар нэмэгдүүлэх үүднээс багш нарыг гадаад болон дотоод сургалтад хамруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг зохион байгуулах | Туршлага судлах, багшлах ур чадвар нэмэгдүүлэх үүднээс багш нарыг гадаад болон дотоодын сургалтад хамруулах талаар холбогдох нэгжид санал хүргүүлж, сургалтад хамруулах | <p><b>Тоо:</b> Тухай бүр</p> <p><b>Чанар:</b> Багш нарын мэдлэгийн цар хүрээ нэмэгдэж, сургалтын агуулга, чанар өөрчлөгдөн сайжирсан байна.</p> <p><b>Хугацаа:</b> 2019-2020 он</p>                                                                                                                                                                                       | Багш нарыг гадаад болон дотоодын сургалтад оролцуулж, олж авсан мэдлэгээ татварын албадын ажилтан, албан хаагчдад түгээх ажлыг гүйцэтгэсэн байна.                                                   | Төрийн захиргааны удирдлагын газар | Сургалтын төв                                                                |
| 2.2 | Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран татварын бодлого чиглэлийг тодорхойлох мэргэжлийн сургалт, уралдаан тэмцээн зохион байгуулах                 | Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран татварын бодлого чиглэлийг тодорхойлох мэргэжлийн сургалт, уралдаан тэмцээн зохион байгуулах                             | <p><b>Тоо:</b> Жилийн төлөвлөгөөнд тусгагдснаар</p> <p><b>Чанар:</b> Татварын онол, судалгаанд суурилсан үр ашиг бүхий татварын орчинг бүрдүүлэх бодлого чиглэлийг тодорхойлсон сэдвээр, өргөн хүрээгээр зохион байгуулсан байна.</p> <p><b>Хугацаа:</b> 2019 он</p>                                                                                                      | Татварын онол, судалгаанд суурилсан татварын бодлогын чиглэлээр сургалт эсвэл уралдаан тэмцээн зохион байгуулснаар шалгаруулсан мэдээллийг татварын албадын ажилтан, албан хаагчдад түгээсэн байна. | Сургалтын төв                      | Сургалтын төв, Төрийн ба төрийн бус байгууллага                              |
| 2.3 | Сургалтын сэдэв, агуулгыг өргөн хүрээний судалгаа, мэдээлэл, эрэлтэд үндэслэн боловсруулах                                                                  | Тухайн жилийн сургалтын сэдэв, агуулгыг өргөн хүрээний судалгаа, мэдээлэл, татварын албаны эрэлт хэрэгцээнд үндэслэн боловсруулах                                       | <p><b>Тоо:</b> Жилийн төлөвлөгөөнд тусгагдснаар</p> <p><b>Чанар:</b> Багш нар сургалтын материалыг боловсруулахдаа татварын албадаас хэрэгцээ, шаардлагатай байгаа сэдвийн судалгаа авч, олон улсын туршлага, ном товхимол, цахим орчноос сүүлийн үеийн мэдээ, мэдээллийг ашиглан боловсруулж сургалтыг үр дүнтэй болгосон байна.</p> <p><b>Хугацаа:</b> 2019-2020 он</p> | Багшийн боловсруулсан сургалтын материал нь танхимын болон цахим системээр суралцагч нарт ашиглахад ойлгомжтой, хэрэгцээ, шаардлагыг хангасан байна.                                                | Сургалтын төвийн дарга             | Сургалтын төвийн багш нар болон сургалт зохион байгуулах бүх албан тушаалтан |

|                                                                                                   |                                                                                                                           |                                                                                                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                                                                       |                                                                                                                                                                          |                                    |                                                |
|---------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------|------------------------------------------------|
| 2.4                                                                                               | Сургалтын төвд 3-аас дээш жил тогтвор суурьшилтай, идэвхи санаачлагатай ажилласан багшийг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх | Ажиллах хугацаандаа идэвх санаачлагатай, шинэ бүтээл гарган, судалгаа шинжилгээний ажил хийж асуудал дэвшүүлэн ажилласан багшийг урамшуулах тогтолцоог бүрдүүлж, удирдлагуудад санал хүргүүлэх                        | Тоо: Тухай бүр<br>Чанар: Багш нар ажиллах хугацаандаа байнга шинэ санаа, мэдээ мэдээллийг олж судлах, судалгаааны ажил хийж, дүнгэлт гарган асуудал дэвшүүлэн ажилласнаар сургалтад ашиглах сургалтын материалын чанар сайжирна.<br>Хугацаа: 2020 он                  | Багш нар идэвх санаачлагатай, шинэ бүтээл гарган, судалгаа шинжилгээний ажил хийж асуудал дэвшүүлэн ажилласан багшийг урамшуулах тогтолцоог бүрдүүлж шийдвэрлэсэн байна. | Төрийн захиргааны удирдлагын газар | Сургалтын төв                                  |
| <b>3. Татварын албаны хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, идэвхжүүлэлтийн удирдлагыг хөгжүүлэх</b> |                                                                                                                           |                                                                                                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                                                                       |                                                                                                                                                                          |                                    |                                                |
| 3.1                                                                                               | Ажилтан, албан хаагч нарыг идэвхжүүлэх, урамшуулах тогтолцоог бүрдүүлэх                                                   | Ажилтан, албан хаагч нар ажлын чиг үүрэгтээ манлайлан мэдлэг, ур чадвараа дайчлан ажиллахын зэрэгцээ шинэ санаа, арга барилд суралцах, шинээр сурсан зүйлээ бусдад мэдээлэх, хуваалцах ажлыг зохион байгуулах         | Тоо: Жилийн төлөвлөгөөнд тусгагдснаар<br>Чанар: Ажилтан, албан хаагч өөрсдийнхөө хариуцсан ажилд манлайлан авъяас мэдлэг чадвараа дайчлан ажиллахын зэрэгцээ шинээр сурсан зүйлээ бусдад мэдээлэхэд чиглэсэн байна<br>Хугацаа: 2019 он                                | Манлайлан ажилласан, шинийг санаачилсан ажилтан, албан хаагчдаас бусад байцаагчид суралцаж мэдлэг, чадвараа дээшлүүлсэн байна.                                           | Сургалтын төв                      | Сургалтын төвийн ТУАБ В.Нарантуяа ТУБ Ш.Ундраа |
|                                                                                                   |                                                                                                                           | Ажилтан, албан хаагч нар ажлын чиг үүрэгтээ манлайлан мэдлэг, ур чадвараа дайчлан сургалтад идэвхитэй оролцож, мэдлэгээ бусдад хуваалцсан суралцагчийг удирдлагын зүгээс идэвхжүүлэн, урамшуулах тогтолцоог бүрдүүлэх | Тоо: Жилийн төлөвлөгөөнд тусгагдснаар<br>Чанар: Ажилтан, албан хаагч өөрсдийнхөө хариуцсан ажилд манлайлан авъяас мэдлэг чадвараа дайчлан ажиллахын зэрэгцээ шинээр сурсан зүйлээ бусдад мэдээлэх, хуваалцахад удирдлагын зүгээс дэмжиж ажиллана.<br>Хугацаа: 2019 он | Манлайлан ажилласан, шинийг санаачилсан ажилтан, албан хаагчдыг удирдлагын зүгээс идэвхжүүлэн, урамшуулах тогтолцоог бүрдүүлсэн байна.                                   | Төрийн захиргааны удирдлагын газар | Татварын албад                                 |

## СУРГАЛТЫН ТӨВ